

III. Тогтох - Хууль сахиулахын удирдлагын академийн
8042 дугаар дамжааны суралцагч
В.Пүрэвбаасан - Хилийн албаны удирдлага, стратегийн
профессорын багийн (дэд профессор, хурандаа

ХҮНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ТҮҮНД НӨЛӨӨЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛҮҮД, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ АРГА ЗАМ

Хураангуй: Хүний аюулгүй байдлыг хангах гол баталгаа бол хууль, хуулийг биелүүлэх, эдийн засаг, нийгэм, байгаль орчны холбогдох чиглэлүүдээр хуулийн зохистой орчинг бүрдүүлэх явдал юм.

Түлхүүр үг: хүний аюулгүй байдал, хүний аюулгүй байдалд нөлөөлж буй хүчин зүйлүүд.

Эрдэмтэн судлаачид “Аюулгүй байдал” гэдэг ерөнхий ойлголтыг янз бүрээр тайлбарласан байдаг. Энэ ойлголт тодорхой тохиолдолд субъектын аюулгүй байдлын өвөрмөц онцлогийг илэрхийлэхийн зэрэгцээ, олон салбарт хэрэглэж болох нийтлэг утга агуулагдаж байдаг. Аюулгүй байдлын талаарх энэхүү ойлголтыг “Британика” нэвтэрхий тольд “Аюулгүй байдал-амар тайван, бат бэх, итгэлтэй байх нөхцөл байдал, аюул болон эрсдэлээс чөлөөтэй байх”, Оксфордын Англи хэлний тольд “Аюулгүй байдал-амар тайван, бат бэх итгэлтэй нөхцөл”, гэсэн бол Я.Цэвэлийн Монгол хэлний товч тайлбар тольд “аймаар юмгүй, айх болгоомжлох шаардлагагүй” гэж тайлбарлажээ.

Монгол Улсын “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д Үндэсний аюулгүй байдал гэж Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсан байдлыг хэлнэ гэж заасан ба үндэсний язгуур ашиг сонирхолд Монголын ард түмэн, соёл иргэншил оршин тогтнох, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэр, хил хязгаарын халдашгүй байдал болон бүрэн бүтэн байдал, үндэсний эв нэгдэл, үндсэн хуульт байгууллын аюулгүй байдал, эдийн засгийн бие даасан байдал, экологийн тэнцвэрт хөгжил багтана.

“Хүний аюулгүй байдал” нь үндэсний аюулгүй байдлын салшгүй нэг хэсэг юм. Энэ тухай онолын үзэл баримтлалыг авч үзвэл иргэдийн аюулгүй байдлыг хангах нь төрийн үүрэг юм. Гэхдээ судлаачид үзэхдээ “Энэ бол төрийн үүрэг” гэж үзэж байхад зарим нь хувь хүн өөрийнхөө аюулгүй байдлыг хангах ёстой гэж үздэг. Харин Үндсэн хууль болон бусад хуулийн хүрээнд хүний эрхийг хамгаалах талаасаа сайн гаргаж өгсөн байдаг. Монгол

Улсын их хурлын 48 дугаар тогтоолоор батлагдсан Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.4-т "Хүний аюулгүй байдал" гэдэгт "Монгол хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах, амьдрах орчин, орон байрны аюулгүй нөхцөлийг баталгаажуулах, гэмт хэрэг, халдлагын золиос болохоос хамгаалах нь хүний аюулгүй байдлыг хангах үндэс мөн¹ " гэж заасан байна.

Хүн төрөлхтөн үүсэж, ухаан орсон цагаасаа өөрийн амьдрал, ахуйн аюулгүй байдлаа хангахын тулд хүрээлэн буй орчноо танин мэдэх, учрах аливаа аюулаас өөрийгөө хамгаалах талаар анхаарч, арвин их эрдэм мэдлэгийн сан, туршлага, материаллаг зүйлс бий болгожээ. Гэхдээ шинжлэх ухааны мэдлэг амьдралын хамгийн үнэт баялаг, орчиндоо нөлөөлөх хамгийн үнэт хэрэгсэл болж, түүнийг эзэмшихдээ хүн байгаль дэлхийг ч, өөрийгөө ч бүрэн устгах шидийг олсон хэр нь дийлэнх хэсэгтээ, тухайлбал, хувь хүний аюулгүй байдал, хоол унд, орон байр г.м. асуудлыг шийдэж чадаагүй байна.

Өөрөөр хэлбэл, өөрийнхөө аюулгүй байдлыг хангахад оюун ухаан, практик, материаллаг зүйлийг ашиглах бололцоо дэлхийн амьд амьтны үй олон төрөл зүйл дотроос зөвхөн хүнд байдаг онцгой шинж юм².

Иймээс хүн төрөлхтөн өөрийн эсрэг заналхийлж буй хүчин зүйлийг танин мэдэж, урьдчилан сэргийлэх буюу арилгах арга замыг хайж сүвэгчилж байдаг билээ. Хүний аюулгүй байдалд нөлөөлөх хүчин зүйлийг:

- эх сурвалжаар нь: дотоод, гадаад;
- цаг хугацааны хувьд: гэнэтийн, тодорхой хугацааны, түүхэн нэгэн үеийн, мөнхийн;
- хэмжээ далайцаар нь: дэлхий дахины, тив, бүс нутаг гэх мэтчлэн ангилж болно.

Нөгөө талаар хүний аюулгүй байдалд сөрөг нөлөөлөх хүчин зүйлийг шинж чанарын үүднээс нь обьсктив болон, субъектив, учруулах аюул заналын магадлалаар нь бодит болон болзошгүй хэмээн үздэг. Хүний аюулгүй байдлыг ханган бэхжүүлэхэд "болзошгүй" үед тодруулан тогтоож арилгах, субъектив аюулыг цаг тухайд нь арилгах замаар бодит аюулыг багасгах, урьдчилан сэргийлж байдаг ажээ.

Урт удаан түүхийн турш аюулгүй байдлын тухай ойлголт нь улс орнууд, газар нутаг, үндэсний эрх ашиг болон гадаад улс төрийн үйл ажиллагаагаар хамгаалах гэсэн явцуу байдлаар тайлбарлаж байжээ. Энэхүү

¹ Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоол.

² Мухамеди Х. Хүний аюулгүй байдалд нөлөөлөх гадаад, дотоод хүчин зүйл. УБ.. 2000. 51 лэх тал.

ойлголт нь ихэнхдээ төрт улсад хамааралтай байсан болохоос жирийн хүмүүст төдийлэн холбогдол багатай байсан билээ. Дэлхий дахинд жирийн хүмүүсийн хууль ёсны эрх ашиг умартагдаж, тэдний хувьд одөр тутмын амьдрал хэвийн үргэлжлэх нь аюулгүй байдлын гол үзүүлэлт байсаар иржээ. Өөрөөр хэлбэл, жирийн хүмүүсийн дийлэнх олонхи нь аюулгүй байдал гэдгийг өвчин зовлон, ажилгүйдэл, гэмт хэрэг, нийгмийн зирчил, улс төрийн харгислал, экологийн сүйрэлгүй байхыг ойлгодог байна.

Хүмүүс юуны түрүүнд өөрсдийнхөө аюулгүй байдал нь бат хаалт хамгаалалтгүй байгаагаа мэдрэх нь өдөр тутмын жирийн амьдралаас урган гардаг хийгээд дэлхий дахинд учрах ямар нэгэн сүйрлээс түүндээ илүү их санаа зовдог. Хүн орох орон байр, өмсөх хувцас, амь зуух ажил хөдөлмөр эрхлэх, гэмт хэрэгтний гарт өртөлгүй эсэн мэнд байж, үр хүүхдээ өсгөн бойжуулж, насаа элээхийг хүсдэг. Иймд хүн төрөлхтөний аюулгүй байдлын асуудал нь хүний хэвийн амьдралд эрхэм чанарын асуудал болон тавигддаг.

Хүн төрөлхтөний аюулгүй байдлын асуудалд түүний илүү их ач холбогдолтой дөрвөн шинж чанарыг анхааран үздэг. Үүнд:

1. Хүн төрөлхтөний аюулгүй байдлын тухай ойлголт нь түгээмэл шинжтэй байдаг. Энэ нь гэр бүл, хамт олон, үндэстэн ард түмний оршин амьдрах нь байгаль, нийгмийн нөхцөл, орчин цаг нь тэдгээрийн үл шалтгаалах, тааламжтай ч бай, тааламжгүй ч бай объектив бодит байдлын хэлбэртэй байж бодит шаардлагыг тулгасан байдаг. Гэхдээ дэлхийн өнцөг булан бүрт тэдгээрийн хир хэмжээ харилцан адилгүй боловч, хүн төрөлхтөнд заналхийлж буй эдгээр бүх аюул нь бодиттой төдийгүй улам өсөн нэмэгдэж байна.

2. Хүн төрөлхтөний аюулгүй байдал нь харилцан шалтгаалах шинжтэй. Энэ нь дэлхийн аль нэг хэсэгт хүмүүсийн аюулгүй байдал нь аюул заналд өртвөл, тэр нь дэлхийн бүх орнуудад нэгэн адил нөлөөгөө тусгана. Өлсгөлөн, халдварт өвчин, байгаль орчны бохирдол, мансууруулах бодисын худалдаа, алан хядах ажиллагаа, угсаатан хоорондын мөргөлдөөн г.м. нь тухайн улс үндэстний хил хязгаараас хальж, хор уршиг нь дэлхий нийтийн аюулгүй байдалд заналхийлдэг.

3. Хүн төрөлхтний аюулгүй байдлыг хангахад урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах нь учирч болзошгүй аюулыг илрүүлэн зайлуулах болон эхний шатандаа хязарлахад ихээхэн үр ашигтай хэмээн үздэг.

4. Хүн төрөлхтөний аюулгүй байдал нь хүний асуудал юм. Хүний хэрэгцээ хир зэрэг хангагдсан, хэрхэн аж төрж, чөлөөт сонголтоо хийж, зах зээлд хэрхэн оролцож байгаа болон тайван ба тайван бус орчинд аж төрөхөөс аюулгүй байдал нь ихээхэн хамаардаг нь ойлгомжтой юм.

Судлаачид хүний аюулгүй байдал хэмээх ойлголтонд үндсэн 2 талыг ялган авч үздэг. Үүнд: Нэгдүгээрт- өлсгөлөн, өвчин зовлон, залхаан цээрлэх зэрэг байнгын аюул заналаас чөлөөтэй байх учиртайг онцолдог бол,

Хоёрдугаарт- нийгэм, ажлын байр, гэр бүлийн өдөр тутмын амьдралд гэнэтийн болон эмгэг гажуудлаас хамгаалагдах явдал хэмээн үздэг' .

Ийм төрлийн аюул занал нь үндэсний орлогын ямар ч түвшинд нийгмийн хөгжлийн үе шатыг үл харгалзан оршиж байдаг аж. Хүн төрөлхтөний аюулгүй байдлыг буруулах үйл явц аажуу тайван байдлаар юм уу хурц, сүртэй түгшүүртэйгээр ч илрэн гардаг байна.

Аюулгүй байдлыг удаан хугацааны турш явцуугаар, тухайлбал хүний гэхээсээ илүү үндэсний, улсын аюулгүй байдлыг голлон, үзэж, тайлбарлаж ирсэн билээ. Энэ нь ч түүхийн тодорхой үед үндэслэлтэй байсан. Гэвч хүйтэн дайны үе түүх болон үлдэж байгаа энэ үед, олон улсын шинэ нөхцөл байдалд хүний аюулгүй байдлын асуудлуудад улам их анхаарах болж байгаа нь зүй ёсны хэрэг юм. Хүний аюулгүй байдал нь өөр хоорондоо холбоотой эдийн засгийн, хүнсний, эрүүл ахуйн, байгаль орчны, мэдээллийн, улс төрийн гэх мэт өргөн хүрээтэй олон асуудал, хүчин зүйлсийг хамардаг. Хүнд учирдаг аюул занал хаа ч адил, хүний аюулгүй байдлыг хангах нь нийтлэг зорилт мөн.

Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3,2-т **"Эдийн засгийн аюулгүй байдал"** гэдгийг эдийн засгийн бие даасан байдлаа хангаж хөгжих, байгальд ээлтэй, хүний аюулгүй, амгалан амьдрах боломжийг бүрдүүлсэн тогтвортой хөгжлийн загварыг бий болгох нь эдийн засгийн аюулгүй байдлыг хангах үндсэн нөхцөл мөн² гэж заасан байна.

Үүнээс харахад нийгэмд тогтсон үзэл болох хүнс, хоол тэжээл хувцас хунар, орон байр зэрэг нь л хүрэлцээтэй бол эдийн засгийн хувьд аюулгүй байна гэсэн уламжлалт ойлголт эвдэгдэж байна. Энэ бүхэн нь аюулгүй байдлынх биш, хүний амьдралын хэрэгцээний асуудал байхад харин эдийн засгийн аюулгүй байдал нь илүү өргөн хүрээний асуудал юм,

Өөрөөр хэлбэл, хүн амьдрахын тулд хэрэгцээгээ хангах шаардлагатай бол, амьдралынхаа туршид хөгжих явцдаа эдийн засгийн хувьд шаардлагатай нөхцөл бололцоогоор хангагдах ёстой. Энэ нөхцөл бололцоо хэрхэн хангагдаж байгаагаар нь эдийн засгийн хувьд **аюултай, аюулгүй** гэдгийг тодорхойлж байна. Одоо дэлхий дахинд эдийн засгийн аюулгүй байдлыг

¹ Мухамеди Х. Хүний аюулгүй байдалд нөлөөлөх гадаад, дотоод хүчин зүйл. УБ., 2000. 210 дахь тал.

² Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоол.

үндсэн хоёр үзүүлэлтээр хэмжих хандлага ажиглагдаж байна¹. Үүнд: орлого болон ажил эрхлэлтийн асуудал юм. Тус бүрд нь задалж үзвэл:

Хэмжүүр 1.

Орлого: Энэ нь ажил хөдөлмөр эрхлэлтийн үр дүн бөгөөд хүний эдийн засгийн аюулгүй байдлыг хэмжих үндсэн хэмжүүр юм. Энэ хэмжүүрээр доорх хэд хэдэн аспектиудыг илрүүлэн гаргаж болно.

- Орлогын найдвартай байх: Энэ асуудал нь нарийвчилсан тоо баримт зэргээр гаргаад тогтоох болохгүй, эдийн засаг, нийгмийн гадаад дотоод олон хүчин зүйлсээс хамаарах асуудал юм.

- Орлогын хүрэлцээтэй байх: Гол нь олсон орлого нь тухайн үеийн эдийн засгийн /инфляци, бараа бүтээгдэхүүний үнийн нэмэгдэл/ асуудлуудтай хэрхэн нийцэж бодит орлого болж чадаж байна уу гэдгээр тодорхойлно.

Амьдралын түвшин: Дээрх үзүүлэлтүүдийг гаргасны үндсэн дээр суурилан иргэдийн амьдралын түвшин ямар байгааг тодорхойлж болох ба энэ нь орлогын хэмжүүрийн эцсийн зорилго юм.

Хэмжүүр 2.

Ажил эрхлэлт: Энэ хэмжүүрээр илрүүлэх асуудлууд нь:

- Ажил эрхлэгчид болон ажилгүйчүүдийн хувь: Манайд энэ талын мэдээ баримтыг боловсруулж гаргадаг боловч зарим нь учир дутагдалтай байна. Статистикийн 2017 оны дөрөвдүгээр улирлын мэдээгээнээс харахад ажилгүйдлийн түвшин нь 2,8 хувь байна.

Ажилгүйдлийн түвшинг 5 хувь байх тохиоддолд хэвийн гэж үздэг албан ёсны дүгнэлттэй харьцуулахад Монгол Улсын хувьд тулгамдсан асуудал биш мэт харагдаж байна. Учир нь ажилгүйдлийн албан ёсны түвшинг ажилгүй, ажил хайж байгаа хэмээн хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн байгууллагад албан ёсоор бүртгүүлсэн хүмүүсийн тоогоор тооцож байгаа юм. Ажилгүй хүмүүс тэр бүр хөдөлмөр зуучлалын албанд бүртгүүлдэггүй, зарим хүмүүс ажилтай боловч өөр ажил хайх зорилгоор бүртгүүлдэг зэргээс дээрх тоо баримт нь олон улсын стандартад нийцэхгүй байна.

Ажилгүй болох эрсдэл: Нийгэм тогтвортой, нийгэм эдийн засгийн үзүүлэлтүүд эерэг гарч, үйлдвэрлэлийн салбар хөгжиж байх үед ажилгүй болох эрсдэл харьцангуй бага байдаг бол, эдийн засгийн хямрал, үйлдвэрлэлийн салбарын уналтын үед ажилгүй болох эрсдэл нэмэгддэг гэдэг ч албан ёсны түвшинд судалж, нэгтгэн боловсруулж, дүгнэлт хийгээгүй асуудал юм.

¹ Стратеги судлал сэтгүүл. УБ., 2013. №61.239 дэх тал.

Ажилгүйдлийн эсрэг авах хамгаалалт: хүнийг ажилгүй болгох эрсдэлд оруулахгүйн тулд төрийн зүгээс авах арга хэмжээнүүдийг хэлж байгаа юм. Арга хэмжээ гэдэг нь ажлын байраар хангагдаж чадахуйц нийгэмд эрэлт хэрэгцээтэй мэргэжил боловсролыг залууст эзэмшүүлэх, төрийн зүгээс ажил олгогч эздийг төрөл бүрээр урамшуулахад чиглэсэн болон үйлдвэрлэлийг дэмжих замаар нэмж ажлын байр гаргах, нийгмийн тодорхой бүлгийнхнийг /тахир дугуу/ дэмжин байгууллага, аж ахуйн нэгж бүхэн тодорхой тооны иргэдийг тохирсон ажлын байранд нь ажиллуулах гэх мэтийн бодлогуудыг боловсруулж, хэрэгжүүлэхийг хэлж байна.

Хүнсний аюулгүй байдал: Дэлхийн эрүүл мэндийн байгууллага болон НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас хүнсний аюулгүй байдал гэж "хүнсний зүйлийн хангамж, чанар, эрүүл ахуйн зохистой хэм хэмжээ хангагдсан байдлыг хэлнэ"¹ гэж тодорхойлсон байдаг.

Хүнсний аюулгүй байдал нь үндсэн гурван тулгуураас тухайлбал, хүнсний зүйлийн хангамж, хүрэлцээ, чанар эрүүл ахуй, шим тэжээлийн байдлаас бүрдсэн цогц асуудал болохыг нотолж байна. Өнөөгийн нийгэмд хувь хүн, өрх гэр, улс гүрэн, бүс нутаг, дэлхийн хэмжээнд хүнсний аюулгүй байдлын бодит үнэлгээг гаргахдаа дээрх зарчмуудаас гадна өрхийн төсөвт хүнсний бүтээгдэхүүний эзлэх хувь хэмжээг чухалчилдаг болоод байна.

Олон улсын жишигт аливаа улс орон хүнсний хэрэгцээнийхээ 30-аас дээш хувийг импортоор, түүний дотор 20-оос дээш хувийг нэг улсаас авдаг бол хүнсний баталгаа алдагдах хараат байдалд орсон гэж үздэг. Дээрх хэмжүүрээр үнэлж үзвэл манайд хүнсний бүтээгдэхүүний хангамж хүрэлцээтэй боловч хүн амын амьдралын боломж, худалдан авах чадвараас хамаарсан хүнсний бүтээгдэхүүний хүртээмж анхаарах асуудлын нэг болоод байна.

"Эрүүл мэндийн аюулгүй байдал": Хүний аюулгүй байдлын нэг чухал бүрэлдэхүүн нь эрүүл байх асуудал. Хүн эрүүл байна гэдэгт бие эрхтэн, сэтгэл санааны хувьд төдийгүй, нийгмийн хувьд эрүүл сайхан аж төрөхийг хэлнэ. Хүн төрөлхтөний түүхэн дэх нийгэм, эдийн засгийн хөгжил, хотжилт, үйлдвэржилт зэрэг үйл явцуудын нөлөөгөөр хүний эрүүл мэнд нь зөвхөн тухайн хүнээс өөрөөс нь бус бусад олон хүчин зүйлсээс хамаарах болжээ. Тиймээс хүний эрүүл мэндийн аюулгүй байдлыг хангах асуудал нь зөвхөн тухайн хүний хариуцлагын асуудал биш, хамт олон, нийгмийн байгууллагууд, төрийн институтуудын оролцоотой шийдэгдэх асуудал юм.

Улс орнууд НҮБ-аас гаргасан илтгэлд дурдсан эрүүл мэндийн аюулгүй байдлын шалгууруудаас улс орныхоо онцлогт тохируулан хүнийхээ

¹ Стратеги судлал сэтгүүл. УБ., 2009. №49. 119 дэх тал.

аюулгүй байдлыг хэрхэн хангагдаж байгааг тодорхойлж байна. Үүний нэгэн адил монгол хүний эрүүл мэндийн аюулгүй байдал алдагдаж байна уу, хэвийн байна уу гэдгийг тодорхойлох хэд хэдэн хэмжүүр үзүүлэлтийг дэвшүүлж байна.

Хэмжүүр 1. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж. Энэ шалгуураар хүний аюулгүй байдал хэрхэн хангагдаж байгааг 2 үндсэн хэмжүүрээр тодорхойлно. Үүнд:

- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хүрэлцэхүйц байх,
- Хүртээмжтэй байх

Хэмжүүр 2. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар. Энэ нь ЭМБ-уудын тоног тохөөрөмж болон эрүүл мэндийн үйлчилгээ нь шинжлэх ухааны болон анагаах ухааны үндэслэлтэй байх асуудал юм. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын хэмжүүрээр хүний аюулгүй байдлыг үнэлэхэд хангалттай баримт материал, судалгаа одоогоор алга байна.

Хэмжүүр 3. ДОХ болон бусад халдварт өвчнөөс сэргийлэх Манайд энэ ажил төрийн зүгээс их идэвхтэй, олон нийтийг хамарсан бодлогоор дамжин хэрэгжиж байна. Гэвч иргэдийн ухамсар, хариуцлагын асуудал сул байгаагаас эрсдэл дагуулахгүй гэх баталгаа байхгүй байна.

Хэмжүүр 4. Эрүүл мэндийн чиг хандлагын хэмжүүр. ЭМЯ-аас гаргасан тайлангаас үзэхэд хавдар, зүрх судасны өвчлөл залуужиж байгаа бөгөөд 10 хүн тутмын нэг нь энэ төрлийн өвчнөөр өвчилжээ. Хүн амын 30-аад хувь нь ямар нэг хэмжээний сэтгэцийн эмгэгтэй байна гэсэн тооцоо ч байна. Эдгээрийн шалтгаан нь удамшил, цус холилдох, төрөх насны эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, уул уурхайн салбарын хөдөлмөрийн хортой нөхцөлийн эсрэг авах арга хэмжээ муу зэрэг юм. Энэ хэмжүүрээр манай улсын хүн амын эрүүл мэндийн хандлага туйлын сөрөг үзүүлэлттэй байна.

Хэмжүүр 5. Эрүүл амьдрах хэв маягийн талаарх хэмжүүр. Мэдлэг болон иргэдийн ухамсар. Эмнэлгийн тусламж авахаар хандах байгаа хүмүүсийн 70 орчим хувь нь урьдчилан сэргийлэх зорилгоор үзлэгт хамрагдах биш ямар нэг өвчнөө эмчлүүлэгсэд байна. Үүнээс иргэдийн энэ талын боловсрол харьцангуй доогуур болох нь харагдаж байна.

Хэмжүүр 6. Аюулгүй хүрээлэн буй орчинд амьдарч байгаа байдал. Дээр үзүүлснээр агаар, болон орчны бохирдол болон гэмт хэрэг хулгай дээрэмд өртөх магадлал өндөр байгаагаараа монгол хүний аюулгүй хүрээлэн буй орчинд амьдрах баталгаа хангагдаж чадахгүй байна.

Хэмжүүр 7. Хууль бус эм, хар тамхины хэрэглээ. Энэ хэмжүүрээр хүний аюулгүй байдал хангагдаж байгааг тодруулбал ялангуяа хууль бус эмийн хэрэглээн дээр сөрөг үр дүн гарна. Манайхан ч хууль бусаар оруулж

ирдэг эмийг ихээр хэрэглэдэг билээ. Гаалийн хяналтаас далдуур хувиараа гаднаас оруулахын ээрэгцээ, дотооддоо дэлхийн стандартад нийцэхгүй эм үйлдвэрлэж байгаа тохиол илэрсээр байна¹.

“Байгаль орчны” буюу “экологийн аюулгүй байдал”: Манай улсад уул уурхайн салбар эрчимтэй хөгжиж байгаа өнөөгийн нөхцөлд хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлыг хангах асуудал нэн хурцаар тавигдаж байна. Хүний эрүүл амьдрах нөхцөл хүрээлэн байгаа орчны цэвэр, ариун байдалтай улам бүр илүү холбогдож байна. Эрүүл амьдрахын олон хүчин зүйлд амьсгалах агаар, уух ус гээд хүрээлэн байгаа орчинтой холбоотой асуудлууд голлох байр суурь эзэлсээр байна. УИХ-аас 2010 онд баталсан «Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал»-ын 3.5-д «Хүрээлэн байгаа орчны аюулгүй байдал»-ын асуудлыг тодорхойлж, анхаарах чухал асуудлыг дэлгэрэнгүй тусган хэрэгжүүлж байна.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд «Байгаль орчны тэнцвэрийг хадгалж, усны нөөцийг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлт, газрын доройтлын сөрөг үр дагаврыг зөөлрүүлэх, биологийн олон янз байдлын хомсдлоос сэргийлэх, орчны бохирдол, байгалийн аюулт үзэгдэл, гамшгийн эрсдэлийг бууруулах нь хүний эрүүл оршин амьдрах, хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлыг хангах үндэс мөн^{1 2}» гэж заасан. Энэ үндэслэлээр шинэ үзэл баримтлалд хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлыг хангах арга замыг таван дэд хэсэгт багцлан авч үзэж тусгалаа. Хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлыг хангахын тулд:

1. Усны нөөцийн хомсдолоос сэргийлэх
2. Уур амьсгалын өөрчлөлт, газрын доройтлын үр дагаврыг бууруулах
3. Биологийн олон янз байдлыг хадгалах, нөөцийн хомсдолоос сэргийлэх
4. Хүрээлэн буй орчны бохирдлыг бууруулах
5. Байгалийн аюулт үзэгдэл, гамшгийн эрсдэлийг бууруулахад эхний ээлжинд анхаарах шаардлагатай байна.

Хүрээлэн байгаа орчны аюулгүй байдалд учруулж болзошгүй аюул занал нь усны нөөцийн хомсдол, хуурайшил цөлжилт, орчны бохирдол, биологийн олон янз байдлын хомсдол буюу байгалийн нөөц баялгийн шавхагдал, байгалийн гамшгийн хөнөөл ихсэх байдлаар илэрч байна. Үүнд дэлхийн уур амьсгалын өөрчлөлт зонхилох нөлөөллийг үзүүлж байгаа нь хүн бүрт ойлгомжтой. Нөгөө талаар хүний үйл ажиллагаанаас үүдэн /байгальтай зүй бусаар харьцаж, аж ахуйн үйл ажиллагаа явуулах, нөхөн сэргээх үйл

¹ Соёлгэрэл Н. Монгол хүний аюулгүй байдлын хэмжүүрүүд. УБ., 2014. 109 дэх тал.

² Стратеги судлал сэтгүүл. УБ., 2011. №53. 51 дэх тал.

ажиллагааг ёс төдий гүйцэтгэснээс/ Монгол хүний амьдрах орчин, оршин тогтнолд бодитой сөрөг нөлөөлөл үзүүлж байгаа, үзүүлэх хандлагатай байна.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.6-д **“Мэдээллийн аюулгүй байдал”** гэдгийг Мэдээллийн салбарт үндэсний ашиг сонирхлыг хамгаалах, төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг баталгаажуулах нь мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндэс мөн¹ гэж заажээ.

Хүний аюулгүй байдлыг хангах, улс орны хөгжлийг дэмжих, үндэсний үнэт зүйлийг хэвшүүлэх, нийгмийн оюун санааг төлөвшүүлэхэд мэдээлэл, мэдээллийн аюулгүй байдал нэн чухал ач холбогдолтой юм.

Улс түмний уялдаа холбоо, харилцан хамаарал бүхий л чиглэлээр өргөжин тэлж байгаа глобалчлалын энэ эрин үед улс орнууд дангаар шийдэж чадахгүй буюу боломжгүй байгаль орчны асуудлууд, үндэстэн дамнасан гэмт хэргүүд, цагаачлал, халдварт өвчний тархалт зэрэг асуудлууд тоо хэмжээ, хамрах хүрээний хувьд нэмэгдэж байгаа нь хүний аюулгүй байдлыг хангах талаар зохистой бодлого явуулах, олон улсын болон бүсийн хэмжээнд хамтын ажиллагааг идэвхжүүлэн бэхжүүлэхийг шаардаж байна.

Улс орон бүр өөр өөрийн онцлогтой, хөгжлийн янз бүрийн түвшинд, байгаль цаг уурын өөр өөр бүсэд байгаа нь хүний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон асуудлуудыг шийдвэрлэхэд хүргэж байгаа юм.

Хүний аюулгүй байдлыг хангах гол баталгаа бол хууль, хуулийг биелүүлэх, эдийн засаг, нийгэм, байгаль орчны холбогдох чиглэлүүдээр хуулийн зохистой орчинг бүрдүүлэх явдал юм. Хүний аюулгүй байдлыг хангах үндэсний бодлого нь нийгэм, эдийн засаг, байгаль орчны болон бусад хүчин зүйлийг харгалзсан оновчтой, цогцолбор арга хэмжээг тусгах нь ойлгомжтой.

Эдгээрийн аль ч чиглэлээр тухайн хүнээс хамаарах зүйл маш их байгаа. Урьд өмнө манай улс орны хөгжилд, хүний өөрийнх нь хөгжилд төр гол үүргийг гүйцэтгэж байсан бол эдүгээ хувийн сектор, төрийн бус байгууллагууд, иргэд өөрсдөө нэн чухал үүрэг гүйцэтгэх болж байна. Төр мэдээж иргэдийнхээ өөрсдийгөө хөгжүүлэх боломжийг, тухайлбал эрүүл мэнд, боловсролын салбарт олгож нэмэгдүүлэх, эдийн засгийн адил боломж олгох, хүн амын бүх хүрээг хамруулахад урьдын адил анхаарна. Харин хувь хүний хариуцлагын асуудал нэн чухал юм.

Хүний аюулгүй байдал ба түүний гол үзүүлэлтүүд

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоол.

Орчин үед “Хүний аюулгүй байдал” гэж юу вэ? гэдгийг янз бүрээр тодорхойлж байна. Монгол хүний сэтгэлгээгээр хамгийн энгийнээр тодорхойлбол: «Айх аюулгүй, дутагдах гачигдахын зовлонгүй. урт наслаж удаан жаргахыг хүний аюулгүй байдал » гэж хэлж болно. «Өргүй бол баян өвчингүй бол жаргал» гэж үздэг Монголчуудын сэтгэлгээг ч дээрхид хамааруулж болно.

Глобалчлалын өнөө үед аюулгүй байдлын зарчмыг хүйтэн дайны үеийнхээс нэлээд өөрөөр авч үзэж байна. Тухайлбал: 1-рт хүний аюулгүй байдлыг улс орны тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, нийгэм, төрийн аюулгүй байдлаас дээгүүр тавих, 2-рт улс орнууд аюулгүй байдлаа зэвсгийн хүчээр хамгаалах үзлээс хүний хөгжлөөр хамгаалах үзэлд шилжих болж байна.

Дээрхи үзлээс үүдэн хүний аюулгүй байдлын гол үзүүлэлтүүдийг Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай харьцуулбал дараахь байдлаар томъёолж болох юм¹. Үүнд:

1. Улс төрийн аюулгүй байдал буюу Монгол Улсын оршин тогтнохын болон нийгэм, төрийн байгуулалын аюулгүй байдал
2. Иргэний эрх, эрх чөлөөний болон бие хүний аюулгүй байдал
3. Эдийн засгийн аюулгүй байдал
4. Шинжлэх ухаан технологийн аюулгүй байдал
5. Мэдээллийн аюулгүй байдал
6. Соёл иргэншлийн болон нийгмийн байгуулалын аюулгүй байдал
7. Хүн ам, удмын сангийн болон эрүүл мэндийн аюулгүй байдал
8. Экологийн аюулгүй байдал
9. Хүнсний аюулгүй байдал.

¹ Очирбат П. Глобалчлалын эрин дэх хүний аюулгүй байдлын тухай ойлгол”. УБ., 2000. 202 дахь тал.